



ХАСБАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН МАТЕРИАЛ

2025 оны 8-р сарын 29-ний өдөр

АГУУЛГА



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“ХЭЭБХ”)-ын зар	03
ХЭЭБХ-ыг эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн тогтоол	04
ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудал:	06
Шийдвэрлэх асуудал:	
1. 2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг зарлан хуваарилах.	06
2. ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах.	11
Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл	17
Тооллогын комиссын бүрэлдэхүүн	22
Саналын хуудасны загвар	23

ХАСБАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАРЛАЛ

Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсгийг үндэслэн ХасБанк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн R-2025-30 дугаар тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("ХЭЭБХ")-ыг эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж буйг үүгээр зарлаж байна.

Компанийн нэр, байршил: ХасБанк ХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72.

Хувьцаа эзэмшигчдэд саналын хуудас хүргүүлэх өдөр: 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдөр брокер, дилерийн компаниудад хүргүүлж, ХасБанкны вебсайт, ХасМийтинг (ХасMeeting) аппликейшнд байрлуулна.

Эчнээ санал цахимаар хүлээн авах хугацаа: 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд хүлээн авна.

Бүртгэлийн өдөр: ХЭЭБХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр байна.

ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудал:

1. 2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг зарлан хуваарилах.
2. ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах.

Хувьцаа эзэмшигч та хурлын материалтай танилцах бол 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн ХасБанкны цахим хуудсанд (www.xacbank.mn) эсхүл хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулагдсан ХасМийтинг аппликейшн-д хандах боломжтой. Та эчнээ саналаа заасан хугацаанд ХасМийтинг аппликейшнээр дамжуулан цахим хэлбэрээр өгнө үү.

Холбоо барих:

Утас: +(976)-8508-1888

Цахим шуудангийн хаяг: investor-relations@xacbank.mn

Ажиллах цагийн хуваарь: ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд.

2025 оны 08 дугаар сарын 26-ны өдөр
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ХЭЭБХ-ЫГ ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТЫН ХЭЛБЭРЭЭР, ЦАХИМААР ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 25 оны 08 сарын 21 өдөр

№ R-2025-30

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг
эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хороо ("СЗХ")-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн, ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ НЬ:

1. ТУЗ нь i) 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн R-2025-29 дүгээр тогтоолоор хагас жилийн ногдол ашиг зарлан хуваарилах, ii) 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн R-2025-31 дүгээр тогтоолоор Банкны Ногдол ашгийн бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулахаар шийдвэрлэснийг; мөн
2. Дээрх асуудлыг эцэслэн батлах зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулах нь зүйтэй гэж ТУЗ үзсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ НЬ:

1. Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("ХЭЭБХ")-ыг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж хуралдуулсугай.
2. ХЭЭБХ Зохион байгуулах комиссын даргаар Банкны Ерөнхий аудитор Б.Биндэръяаг томилсугай. Тус комиссын гишүүдийг холбогдох дотоод журмын дагуу томилохыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.
3. ХЭЭБХ-ын мэдэгдлийг 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн дотор СЗХ болон Монголын Хөрөнгийн Бирж ("МХБ")-д хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.
4. ХЭЭБХ зохион байгуулах тухай зар мэдээг МХБ-ийн цахим хуудас, өдөр тутмын сонин, Банкны албан ёсны веб сайт (www.xacbank.mn), сошиал орчин дахь албан ёсны хаягаар болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, зарын давталтыг тийнхүү нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх зарласан хэлбэрээр дахин нэг удаа нийтэд мэдээлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
5. Эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж буй ХЭЭБХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр байхаар тогтоосугай.

ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ц/Х-72,
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Веб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn

6. ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, саналын хуудас болон бусад холбоотой баримт бичгийг 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
7. ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудалтай холбоотой баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтаар, саналын хуудсыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчид шийдвэрлэх асуудалтай холбоотой баримт бичигтэй ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулагдсан ХасМийтинг аппликейшнээр дамжуулан танилцах боломжийг хангаж ажиллахыг Зохион байгуулах комисст даалгасугай.
9. Эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж буй ХЭЭБХ-аас гарсан шийдвэр, бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд МХБ, СЗХ-д хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ



Хурлаар шийдвэрлэх асуудал:

2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг зарлан хуваарилах:

ХУРААНГУЙ

2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга



Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг болон ХасБанк ХК-ийн дүрмийн 8.6(ii) дахь заалт, мөн 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрт үндэслэн ХасБанк ХК-ийн 2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд дараах байдлаар ногдол ашиг тараахыг санал болгож байна.

Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг:	18.00 төгрөг
Ногдол ашгийн нийт дүн:	18.9 тэрбум төгрөг (халаасны хувьцааны тооноос хамааран өөрчлөгдөж болзошгүй)
Ногдол ашиг тараах огноо:	Холбогдох зөвшөөрөл гарснаар (дараагийн хуудсыг үзнэ үү)
Ногдол ашиг тараах хэлбэр:	ҮЦТХТ-өөр дамжуулан, дансаар
Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр:	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болох 2025 оны 09-р сарын 15-ны өдрийг Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоох

ӨМНӨХ НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга

ХасБанк ХК 2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 18.00 төгрөгийн ногдол ашиг тараахаар санал болгож байна.



НОГДОЛ АШИГ ТАРААСНЫ ДАРААХ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга

Санал болгож буй ногдол ашгийг тарааснаар нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтэд 0.45 нэгж хувийн нөлөө үзүүлнэ. Гэсэн хэдий ч, ХасБанкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт байвал зохих хэмжээ болох 12.5%-иас өндөр хэвээр хадгалагдана.

	2025 оны 1-р хагас
Татварын дараах цэвэр ашиг (Тэрбум төгрөгөөр)	85.9
Ногдол ашиг (Тэрбум төгрөгөөр)	18.9
Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг (Төгрөгөөр)	18.00
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт (санал болгож буй ногдол ашиг тараахаас өмнөх байдлаар)	18.5%
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт (санал болгож буй ногдол ашиг тараасны дараах байдлаар)	18.0%

НОГДОЛ АШИГ ТАРААХ ХУГАЦАА

2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга

Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл ногдол ашиг хуваарилах шийдвэр батлагдсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойш 7 хоногоос хэтрүүлэлгүйгээр Банкны ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр тараана.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2025 оны 08 сарын 21 өдөр

№ R-2025-29

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.6.(ii) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банк нь 2025 оны эхний хагас жилийн байдлаар 85.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 18.3%-д хүргэж ажилласан болохыг;
2. Банкны Дүрэмд зааснаар ногдол ашиг хуваарилах асуудал нь стратегийн асуудал болохыг;
3. Банкны гүйцэтгэх удирдлага нь Банкны 2025 оны эхний хагас жилийн ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах ("Хагас жилийн ногдол ашиг")-ыг ТУЗ-д санал болгосныг; мөн
4. ТУЗ нь Банкны Дүрмийн 8.6 (ii) дахь заалтын дагуу дор дурдсан дүнгээр Хагас жилийн ногдол ашгийг зарлан хуваарилах шийдвэр гаргуулахаар хувьцаа эзэмшигчдэд санал болгож буйг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсан тохиолдолд, Хагас жилийн ногдол ашигт нэгж хувьцаанд 18.00 (арван найм) төгрөг зарлан хуваарилахыг дэмжсүгэй.
2. Монголбанкнаас зөвшөөрч, Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("ХЭЭБХ")-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг тухайн хурал зохион байгуулагдах хэлбэрээс үл хамааран Хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Монголбанкнаас зөвшөөрч, Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан өдрөөс хойш 7 хоногийн дотор ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлсүгэй. Ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан тараах ба Санхүүгийн Зохицуулах Хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 тоот "Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай" тогтоолын дагуу Банкны нөлөө бүхий

ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Вeb: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn

хувьцаа эзэмшигчид бичгээр урьдчилан хүсэлт гаргасан тохиолдолд ногдол ашгийг банкны харилцах дансанд нь шилжүүлсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ



Хурлаар шийдвэрлэх асуудал:

ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах:

ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хороо нь тус Хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 дугаар “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолын зарим заалтуудыг ХасБанк ХК (“Банк”)-ийн Ногдол ашгийн бодлогод тусгаж, нэмэлт өөрчлөлт оруулахыг үүрэг болгосон.

Үүний дагуу Банкны Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн R-2025-31 тоот тогтоол баталж Ногдол ашгийн бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулахаар Хувьцаа эзэмшигчдэд танилцуулж байна.

1. 3.2 дахь хэсгийн “Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ” гэсний дараа “Ногдол ашиг зарлан хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.” гэж доорх байдлаар нэмэх:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ.	3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ. <u>Ногдол ашиг зарлан хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.</u>

2. 4.1 дэх хэсгийн “эрх бүхий этгээд хэлэлцэн” гэсний дараа “шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн” гэж доорх байдлаар нэмэх:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн шийдвэрлэнэ.	4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн <u>шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн</u> шийдвэрлэнэ.

3. Дараах 3.3, 5.8, 5.9 дэх хэсэг, 5.3.4 болон 5.4.5 дахь заалтыг доорх байдлаар өөрчлөн найруулах:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
3.3 Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн шийдвэрлэснээр ногдол ашиг авах эрхтэй.	3.3 <u>Монголбанкнаас зөвшөөрөл олгосон тохиолдолд</u> , Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн <u>өөс шийдвэрлэснээр</u> шийдвэрлэж, <u>Хувьцаа эзэмшигчдийн эцэслэн баталснаар</u> ногдол ашиг авах эрхтэй.
5.3.4 Ногдол ашиг тараах хэлбэр (Банк өөрөө эсхүл эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан);	5.3.4 <u>Эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан</u> Ногдол ашиг тараах хэлбэр арга (Банк өөрөө эсхүл эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан);
5.4.5 Банк ногдол ашгийг өөрөө эсхүл мэргэжлийн зуучлагч байгууллагаар дамжуулан тараахын аль нь болох;	5.4.5 Банк ногдол ашгийг өөрөө эсхүл мэргэжлийн <u>Эрх бүхий</u> зуучлагч байгууллагаар дамжуулан <u>ногдол ашиг тараах арга</u> тараахын аль нь болох;
5.8 Банк нь ногдол ашгийг Банкинд данстай хувьцаа эзэмшигчийн цахим болон бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Банкин дахь дансанд шилжүүлэх, харин Банкинд дансгүй хувьцаа эзэмшигчийн хувьд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан хувьцаа эзэмшигчийн нэр дээр бүртгэлтэй банкны дансанд тус тус шилжүүлэх байдлаар төлнө.	5.8 Банк нь ногдол ашгийг Банкинд данстай хувьцаа эзэмшигчийн цахим болон бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Банкин дахь дансанд шилжүүлэх, харин Банкинд дансгүй хувьцаа эзэмшигчийн хувьд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан хувьцаа эзэмшигчийн нэр дээр бүртгэлтэй банкны дансанд тус тус шилжүүлэх байдлаар төлнө. <u>Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 тоот “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолд заасны дагуу Банкны нийт гаргасан хувьцааны тав болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь Банкинд бичгээр хүсэлтээ урьдчилан гаргасан тохиолдолд, ногдол ашгаа арилжааны банкинд дахь харилцах эсхүл хадгаламжийн дансаар хүлээн авч болно. Бусад хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд нь шилжүүлнэ.</u>
5.9 Ногдол ашиг төлөх өдөр нь Монголбанкнаас зөвшөөрөл авсан өдрөөс хойш 15 хоногоос хэтрэхгүй байна.	5.9 Ногдол ашиг төлөх өдөр нь Монголбанкнаас зөвшөөрөл авсан өдрөөс хойш 15 хоногоос хэтрэхгүй байна. <u>Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд, жилийн эцсийн ногдол ашгийг тухайн санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хувьцаа эзэмшигчдэд тараана.</u>

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2025 оны 08 сарын 21 өдөр

№ R-2025-31

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогод
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хороо ("СЗХ") нь Банкны үйл ажиллагаанд хийсэн газар дээрх шалгалтын тайландаа СЗХ-ны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 тоот "Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай" тогтоолын зарим заалтуудыг Ногдол ашгийн бодлогодоо тусгаж, нэмэлт өөрчлөлт оруулахыг Банкнд үүрэг болгосныг; мөн
2. ТУЗ СЗХ-ноос үүрэг болгосны дагуу Банкны Дүрэмд Ногдол ашгийн бодлогыг нийцүүлэхээр Ногдол ашгийн бодлогод дараах нэмэлт, өөрчлөлт оруулахыг батлахаар дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Ногдол ашгийн бодлогод оруулах нэмэлт, өөрчлөлтийг энэхүү тогтоолын хавсралт ёсоор баталж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ



ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн R-2025-31 дүгээр тогтоолын Хавсралт

ХАВСРАЛТ: ХАСБАНКНЫ НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

- 1.1 3.2 дахь хэсгийн “Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ” гэсний дараа “Ногдол ашиг зарлан хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.” гэж доорх байдлаар нэмсүгэй:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ.	3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ. <u>Ногдол ашиг зарлан хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.</u>

- 1.2 4.1 дэх хэсгийн “эрх бүхий этгээд хэлэлцэн” гэсний дараа “шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн” гэж доорх байдлаар нэмсүгэй:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн шийдвэрлэнэ.	4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн <u>шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн</u> шийдвэрлэнэ.

- 1.3. Дараах 3.3, 5.8, 5.9 дэх хэсэг, 5.3.4 болон 5.4.5 дахь заалтыг доорх байдлаар өөрчлөн найруулсугай:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
3.3 Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн шийдвэрлэсэнээр ногдол ашиг авах эрхтэй.	3.3 <u>Монголбанкнаас зөвшөөрөл олгосон тохиолдолд,</u> Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн <u>өөс шийдвэрлэсэнээр</u> шийдвэрлэж, <u>Хувьцаа эзэмшигчдийн эцэслэн баталснаар</u> ногдол ашиг авах эрхтэй.

5.3.4 Ногдол ашиг тараах хэлбэр (Банк өөрөө эсхүл эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан);	5.3.4 <u>Эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан</u> Ногдол ашиг тараах хэлбэр арга (Банк өөрөө эсхүл эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан);
5.4.5 Банк ногдол ашгийг өөрөө эсхүл мэргэжлийн зуучлагч байгууллагаар дамжуулан тараахын аль нь болох;	5.4.5 Банк <u>ногдол ашгийг өөрөө эсхүл мэргэжлийн Эрх бүхий</u> зуучлагч байгууллагаар дамжуулан <u>ногдол ашиг тараах арга тараахын аль нь болох</u> ;
5.8 Банк нь ногдол ашгийг Банкинд данстай хувьцаа эзэмшигчийн цахим болон бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Банкин дахь дансанд шилжүүлэх, харин Банкинд дансгүй хувьцаа эзэмшигчийн хувьд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан хувьцаа эзэмшигчийн нэр дээр бүртгэлтэй банкны дансанд тус тус шилжүүлэх байдлаар төлнө.	5.8 Банк нь ногдол ашгийг Банкинд данстай хувьцаа эзэмшигчийн цахим болон бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Банкин дахь дансанд шилжүүлэх, харин Банкинд дансгүй хувьцаа эзэмшигчийн хувьд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан хувьцаа эзэмшигчийн нэр дээр бүртгэлтэй банкны дансанд тус тус шилжүүлэх байдлаар төлнө. <u>Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 тоот "Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай" тогтоолд заасны дагуу Банкны нийт гаргасан хувьцааны тав болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь Банкинд бичгээр хүсэлтээ урьдчилан гаргасан тохиолдолд, ногдол ашгаа арилжааны банкин дахь харилцах эсхүл хадгаламжийн дансаар хүлээн авч болно. Бусад хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд нь шилжүүлнэ.</u>
5.9 Ногдол ашиг төлөх өдөр нь Монголбанкнаас зөвшөөрөл авсан өдрөөс хойш 15 хоногоос хэтрэхгүй байна.	5.9 Ногдол ашиг төлөх өдөр нь Монголбанкнаас зөвшөөрөл авсан өдрөөс хойш 15 хоногоос хэтрэхгүй байна. <u>Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд, жилийн эцсийн ногдол ашгийг тухайн санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хувьцаа эзэмшигчдэд тараана.</u>



Хувьцаа эзэмшигчдийн хурлын ТОГТООЛЫН ТӨСӨЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

[төсөл]-1

2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас
ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК ("**Банк**")-ийн Дүрмийн 8.6.(ii) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Хувьцаа эзэмшигчид 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан эчнээ санал хураалтаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Ногдол ашиг хуваарилах эсэх нь Банкны Дүрэмд заасан стратегийн асуудал тул Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал эцэслэн батлах шаардлагатай болохыг;
2. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("**ТУЗ**") нь 2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг ("**Хагас жилийн ногдол ашиг**") мөнгөн хэлбэрээр хуваарилахыг 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн R-2025-29 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдэд санал болгосныг; мөн
3. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-өөс санал болгосны дагуу Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд, Банкны Дүрмийн 8.6.(ii) дахь заалтыг үндэслэн дор дурдсан дүнгээр Ногдол ашгийг зарлан хуваарилахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Хагас жилийн ногдол ашигт нэгж хувьцаанд 18.00 (арван найм) төгрөг зарлан хуваарилсугай.
2. Эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулагдаж буй тус Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болох 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийг Хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл энэхүү шийдвэр батлагдсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойш 7 хоногийн дотор ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлсүгэй. Ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан тараах ба Санхүүгийн Зохицуулах Хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 тоот "Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай" тогтоолын дагуу Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид бичгээр урьдчилан хүсэлт гаргасан тохиолдолд ногдол ашгийг банкны харилцах дансанд нь шилжүүлсүгэй.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогод
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ХасБанк ХК (“Банк”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан эчнээ санал хураалтаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ”) нь Банкны үйл ажиллагаанд хийсэн газар дээрх шалгалтаар СЗХ-ны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 тоот “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолын зарим заалтуудыг Ногдол ашгийн бодлогодоо тусгаж, нэмэлт өөрчлөлт оруулахыг Банкинд үүрэг болгосныг;
2. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) СЗХ-ноос үүрэг болгосны дагуу болон Банкны Дүрэмд Ногдол ашгийн бодлогыг нийцүүлэх зорилгоор 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн R-2025-31 тоот тогтоолоороо Ногдол ашгийн бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулахыг санал болгосныг; мөн
3. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-өөс санал болгосны дагуу Ногдол ашгийн бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Ногдол ашгийн бодлогод оруулах нэмэлт, өөрчлөлтийг энэхүү тогтоолын хавсралт ёсоор баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

- 1.1 3.2 дахь хэсгийн “Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ” гэсний дараа “Ногдол ашиг зарлан хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.” гэж доорх байдлаар нэмсүгэй:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ.	3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ. <u>Ногдол ашиг зарлан хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.</u>

- 1.2 4.1 дэх хэсгийн “эрх бүхий этгээд хэлэлцэн” гэсний дараа “шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн” гэж доорх байдлаар нэмсүгэй:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн шийдвэрлэнэ.	4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн <u>шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн</u> шийдвэрлэнэ.

1.3 Дараах 3.3, 5.8, 5.9 дэх хэсэг, 5.3.4 болон 5.4.5 дахь заалтыг доорх байдлаар өөрчлөн найруулсугай:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
3.3 Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн шийдвэрлэснээр ногдол ашиг авах эрхтэй.	3.3 <u>Монголбанкнаас зөвшөөрөл олгосон тохиолдолд</u> , Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн <u>өөс шийдвэрлэснээр</u> шийдвэрлэж, <u>Хувьцаа эзэмшигчдийн эцэслэн баталснаар</u> ногдол ашиг авах эрхтэй.
5.3.4 Ногдол ашиг тараах хэлбэр (Банк өөрөө эсхүл эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан);	5.3.4 <u>Эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан</u> Ногдол ашиг тараах <u>хэлбэр арга</u> (Банк өөрөө эсхүл эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан);
5.4.5 Банк ногдол ашгийг өөрөө эсхүл мэргэжлийн зуучлагч байгууллагаар дамжуулан тараахын аль нь болох;	5.4.5 Банк ногдол ашгийг өөрөө эсхүл мэргэжлийн <u>Эрх бүхий</u> зуучлагч байгууллагаар дамжуулан <u>ногдол ашиг тараах арга тараахын аль нь болох</u> ;
5.8 Банк нь ногдол ашгийг Банкинд данстай хувьцаа эзэмшигчийн цахим болон бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Банкин дахь дансанд шилжүүлэх, харин Банкинд дансгүй хувьцаа эзэмшигчийн хувьд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан хувьцаа эзэмшигчийн нэр дээр бүртгэлтэй банкны дансанд тус тус шилжүүлэх байдлаар төлнө.	5.8 Банк нь ногдол ашгийг Банкинд данстай хувьцаа эзэмшигчийн цахим болон бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Банкин дахь дансанд шилжүүлэх, харин Банкинд дансгүй хувьцаа эзэмшигчийн хувьд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан хувьцаа эзэмшигчийн нэр дээр бүртгэлтэй банкны дансанд тус тус шилжүүлэх байдлаар төлнө. <u>Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 тоот “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолд заасны дагуу Банкны нийт гаргасан хувьцааны тав болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь Банкинд бичгээр хүсэлтээ урьдчилан гаргасан тохиолдолд, ногдол ашгаа арилжааны банкин дахь харилцах эсхүл хадгаламжийн дансаар хүлээн авч болно. Бусад хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд нь шилжүүлнэ.</u>
5.9 Ногдол ашиг төлөх өдөр нь Монголбанкнаас зөвшөөрөл авсан өдрөөс хойш 15 хоногоос хэтрэхгүй байна.	5.9 Ногдол ашиг төлөх өдөр нь Монголбанкнаас зөвшөөрөл авсан өдрөөс хойш 15 хоногоос хэтрэхгүй байна. <u>Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд, жилийн эцсийн ногдол ашгийг тухайн санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хувьцаа эзэмшигчдэд тараана.</u>

ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
08 дугаар сарын 21-ний өдрийн R-2025-30 дугаар тогтоолын Хавсралт 3

Комиссын дарга: Б.Ананд, Партнер, Кэй И Партнерс ХХН

Комиссын гишүүд: Т.Отгон, Хуульч, Кэй И Партнерс ХХН

Г.Хажидмаа, Эрх зүйч, Кэй И Партнерс ХХН

Саналын хуудасны загвар

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
08 дугаар сарын 21-ний өдрийн R-2025-30 дугаар тогтоолын Хавсралт 4

Компанийн нэр: ХасБанк ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар:

Эзэмшиж буй хувьцааны төрөл:

Эзэмшиж буй хувьцааны тоо:

2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд ХасМийтинг аппликейшнээр дамжуулан эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар саналаа өгнө.

Д/д	Шийдвэрлэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	ХасБанкны 2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг зарлан хуваарилах тухай	☐	☐	☐
2.	Ногдол ашгийн бодлогын 3.2 дахь хэсэгт нэмэлт оруулах	☐	☐	☐
3.	Ногдол ашгийн бодлогын 3.3 дахь хэсгийг өөрчлөн найруулах	☐	☐	☐
4.	Ногдол ашгийн бодлогын 4.1 дэх хэсэгт нэмэлт оруулах	☐	☐	☐
5.	Ногдол ашгийн бодлогын 5.3.4 дэх заалтыг өөрчлөн найруулах	☐	☐	☐
6.	Ногдол ашгийн бодлогын 5.4.5 дахь заалтыг өөрчлөн найруулах	☐	☐	☐
7.	Ногдол ашгийн бодлогын 5.8 дахь хэсгийг өөрчлөн найруулах	☐	☐	☐
8.	Ногдол ашгийн бодлогын 5.9 дэх хэсгийг өөрчлөн найруулах	☐	☐	☐

Тайлбар/Санамж:

1. Та эчнээ саналаа заасан хугацаанд зөвхөн ХасМийтинг аппликейшнээр дамжуулан цахим хэлбэрээр өгөх боломжтой.
2. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх бол төлөөлөх хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэлийг ирүүлэн саналаа өгсөн тохиолдолд таны санал хүчинтэйд тооцогдоно.

Энэ хэсгийг ХЭЭБХ-ын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм / Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: _____ / _____

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: _____

